



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/192

Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, 21 дүгээр зүйлийн 21.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дугаар захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2.9.5, 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/142 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хорооны гаргасан зөвлөмжийн дагуу Том оврын нарс модыг бордох бордоог нийлүүлэх болон оршуулгын газрыг ойжуулах, ногоон байгууламжийн чиглэлээр хийгдэж байгаа ажлыг олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчилах ажлуудын зардлын задаргааг хавсралт ёсоор баталсугай.


2. Тушаалын 1-р зүйлд заасан ажлуудын гүйцэтгэгч нартай шууд гэрээ байгуулж, ажлын гүйцэтгэл үр дүнд хяналт тавьж ажиллахыг Тохижилт хог хаягдал, удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр /-т даалгасугай.

3. Дээрх ажилд шаардагдах нийт 35.100.000 /Гучин таван сая нэг зуун мянга /-н төгрөгийг Ногоон байгууламжийн арчилгааны зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 7 дугаар сарын 20 өдрийн
А/192 94/2019 тушаалын хавсралт



БОРДОО ХУДАЛДАН АВАХ, ОРШУУЛГЫН
ГАЗРЫГ ОЙЖУУЛАХ, ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛЭЭР
СУРТАЛЧЛАХ АЖИЛД ШААРДАГДАХ ЗАРДАЛ

Д/д	Зардлын нэр төрөл	Төсөв /сая төгрөг/
1	Доломит бордоо /цагаан гантиг/ авах	5.0
2	Оршуулгын газрыг ойжуулах /бортоготой хайлаас /	8.1
3	Ногоон байгууламжийн чиглэлээр хийж буй ажлыг сурталчлах	9.5
4	Мод, сөөг тарих, арчлах гарын авлага, ном гаргах	2.0
5	Хотын ногоон байгууламжийн талаарх шторк бэлдэх	2.0
6	Тохижилтын чиглэлээр хийж буй ажлыг сурталчлах	8.5
Нийт дүн		35.1